

Гэрээний бичвэр дэх хэл зүй, үгийн сангийн онцлог, хэрэглээ

Намсрайн МӨНХЦЭЦЭГ*

Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академи,

Хэл зохиолын хүрээлэн,

Хэрэглээний хэл шинжлэлийн салбар

Received: June 15, 2025 | Accepted: October 1, 2025 | Published: December 15, 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсад хэрэглэж буй гэрээний баримт бичгийн хэл зүй, үгийн сангийн бүрдэл, утга зүйн онцлогийг хөмрөг хэл шинжлэлийн аргаар судалсан болно. Судалгаанд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ашигладаг түрээс, хөдөлмөр, худалдаа, үйлчилгээ, хамтын ажиллагаа зэрэг төрөл бүхий нийт 84 жишиг гэрээний эхийг сонгон авч, Sketch Engine программ ашиглан тоон болон чанарын шинжилгээ хийжээ. Бүрдүүлсэн хөмрөг нь 270 745 давтагдсан үг (давтагдаагүй тоогоор 15 198)-тэй байна.

Судалгааны үр дүнгээс харахад гэрээний хэл нь стандартчилсан бүтэцтэй, захирамжлах өнгө давамгайлсан, нэр томьёо өргөн хэрэглэдэг онцлогтой байна. Үг зүйн хувьд жинхэнэ нэр, үйл үг хамгийн өндөр давтамжтай бөгөөд “талууд”, “үүрэг”, “эрх”, “гэрээний нөхцөл” зэрэг нэр томьёо гэрээний утга агуулгын цөмийг бүрдүүлж байна. Мөн ирээдүй цагийн “-на/-нэ” төгсгөлтэй үйл үгс (“шийдвэрлэнэ”, “төлнө”, “хариуцна” гэх мэт) их давтамжтай хэрэглэгдэж, заавал биелүүлэх, үүрэгжүүлэх норматив шинжийг илэрхийлдэг нь тогтоогдлоо.

Өгүүлбэр зүйн хувьд нөхцөл заасан урт нийлмэл өгүүлбэр зонхилж, “хэрэв”, “тохиолдолд”, “эсхүл” зэрэг нөхцөлдүүлэн холбох үгс өргөн хэрэглэгддэг нь гэрээний заалтыг тодорхой, хоёрдмол утгагүй болгоход чиглэж байгааг харуулна. Иймээс гэрээний хэл нь маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн баталгааг хангах зорилготой, тогтвортой бүтэц бүхий тусгай хэлний хэрэглээ болохыг уг судалгаа нотолж байна.

* © Н.Мөнхцэцэг, 2025

Email: munkhtsetegn@mas.ac.mn,  <https://orcid.org/0000-0001-5285-0566>

Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Нэр томъёоны хувьд, гэрээний бичвэрт оролцогч талуудын эрх зүйн статустай холбоотой эсрэгцсэн нэр томъёо (жишээлбэл, “гүйцэтгэгч”– “гүйцэтгүүлэгч”, “худалдагч”–“худалдан авагч”, “түрээслэгч”– “түрээслүүлэгч”) зонхилохын зэрэгцээ эдийн засаг, санхүү, техник-технологи, хууль эрх зүйтэй холбоотой гадаад нэр томъёо (“компани”, “банк”, “арбитр”, “стандарт”, “лиценз”, “технологи” зэрэг) идэвхтэй хэрэглэгдэж, орчин үеийн гэрээний харилцааны мэргэжлийн ба олон улсын шинжийг илэрхийлж байна.

Түлхүүр үг: гэрээний хэл, үгийн сан, нэр томъёо, хөмрөг хэл шинжлэл, эрх зүйн бичвэр

Grammatical and Lexical Features and Usage of Contractual Documents

MUNKHTSETSEG Namsrai

Department of Applied Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article examines the grammatical features, lexical structure, and semantic characteristics of contract documents used in Mongolia through a corpus-linguistic approach. The study is based on a selection of 84 model contracts including lease, employment, trade, service, and cooperation agreements used by public and private sector organizations, which were analyzed using quantitative and qualitative methods with the Sketch Engine software. The compiled corpus contains 270,745 words (15,198 word forms).

The findings show that the language of contracts is characterized by a standardized structure, an imperative tone, and extensive use of specialized terminology. From a lexical perspective, nouns and verbs occur with the highest frequency, and terms such as “*taluud*” (parties), *үүрег* (obligations), “*erkh*” (rights), and “*gereenii nökhstöl*” (contractual conditions) constitute the semantic core of contractual texts. In addition, future-tense verbs with the suffix -*na/-ne* (e.g. “*shiidervelene*” (shall decide), “*tölnö*” (shall pay), “*khariutsna*” (shall be liable) occur with high frequency, expressing mandatory and obligation-imposing normative functions.

Syntactically, long complex sentences with conditional clauses predominate, and the frequent use of conditional connectors such as “*kherev*” (if), “*tokhioldold*” (in the case), and “*eskhül*” (or) indicates an orientation toward clarity and the avoidance of ambiguity in contractual provisions. Accordingly, the study demonstrates that contract language represents a specialized, structurally stable form of language use aimed at preventing disputes and ensuring legal certainty.

In terms of terminology, contractual texts predominantly employ contrastive terms denoting the legal status of the participating parties (e.g. “*güitsetgegch*” (contractor)

– *güitsetgüülegch* (contracting party), “*khudaldagch*” (seller) – “*khudaldan avagch*” (buyer), “*türeeslegch*” (lessee) – *türeeslүүlegch* (lessor), alongside active use of foreign terms related to economics, finance, technology, and law (such as “company”, “bank”, “arbitration”, “standard”, “license”, “technology”), reflecting the professional and international nature of contemporary contractual relations.

Keywords: contract language, vocabulary, terminology, corpus linguistics, legal text.

1. Удиртгал

Гэрээ нь зөвхөн бичгээр үйлдсэн баримт биш, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг хууль ёсны үндсэн дээр тогтоож, гүйцэтгэх чухал баримт бичиг юм. Энэ талаар “Гэрээний эцэг нь хууль, эх нь тохиролцоо” (Наранмандах, 2022) гэсэн үг бий. Гэрээ нь эртний түүхтэй. Эртний Мессопотамын (Өнөөгийн Ирак улс)-ын нутаг дэвсгэрт орших шумерын Умма болон Лагаш хотуудын удирдагчдын хооронд байгуулсан гэрээ бол судар бичигт дурдагдсан хамгийн эртний гэрээ гэж түүхчид үздэг. Энэхүү гэрээний нас ойролцоогоор 5000 жил гаруй байх бөгөөд Нийтийн тооллоос өмнөх 3100 онд байгуулж байжээ. Энэ гэрээ нь тухайн хоёр улсын хооронд тогтсон улсын хилийн тухай, түүний халдашгүй дархан байх тухай гэрээ юм (Мөнхбат, 2023). Монголчуудын хувьд, Хүннү гүрний үед мөн хүч хавсран дайн тулаан хийх, эвлэрэл, энх тайвны гээд олон төрлийн гэрээг байгуулдаг байсан түүхтэй. Тухайлбал, Хүннү-Хан улсын хооронд байгуулагдсан найрамдлын гэрээ. Хүннү улсын хөрш улс орнуудтай харилцах гадаад харилцааны нэгэн арга хэлбэр, энх тайвнаар зэрэгцэн орших утга агуулгатай гэрээ юм.

Хүннү улс улам хүчирхэгжсн бэхжихийн хэрээр Хан улс тэднийг зэвсгийн хүчээр дийлэхгүй гэдгээ ухаарч эв найрамдлын гэрээ хэлэлцээр байгуулан энх тайвнаар зэрэгцэн орших арга замыг эрэлхийлж эхэлжээ. Ингэснээр Хятадын Хань улс Хүннүг Төв Азийн хамгийн хүчирхэг улс гэдгийг аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрч НТӨ 198 онд хятадаар “хэцин” буюу “энх ургийн гэрээ” анх байгуулагдсан түүхтэй. НТӨ 162 онд Хан улсын Сяо-Вэньди хаан Хүннүгийн Лаошан шаньюйд илгээсэн захидалдаа “Цагаан хэрэмнээс хойших нум агсагчдын улс нь Шаньюйн зарлигийг дагаж, Цагаан хэрэмнээс урагших түшмэдийн бүс, малгай өмсөгчид суудаг орон нь харин надад захирагдана... Хан улс, Хүннү хоёр бол мөр зэрэгцэх хүчирхэг хөрш улсууд юм” хэмээн дурдсан нь НТӨ 198 онд байгуулсан гэрээний эхийн хэсэг мөн гэж Г.Сүхбаатар үзсэн байдаг. (Төрбат, 2016)

Энэ мэтчилэн, эртнээс нааш гэрээ нь олон улсын, худалдааны, тээвэрлэлтийн, зуучлалын гэх мэт олон төрөл зүйл болон хөгжсөөр иржээ. Түүнчлэн гэрээ хэмээх үгийн гарлыг “Энэ үгийн гарвал түүхийг ухан үзвээс “гэрэгэ” буюу элч

этгээдийн эрх сүр, хүчин чадлыг илэрхийлэх нэгэн төрлийн дипломат эрх ямбын үүсгэл болсон зүйлийн нэршилтэй угшил ойр байгаа нь харагддаг юм” (Хантөгс, 2011) гэх мэтээр авч үзсэн нь бий.

Монгол Улсад бичигдэж буй гэрээний баримт бичгүүд нь төр, хувийн хэвшил, иргэд хоорондын эрх зүйн харилцааг зохицуулах суурь хэрэгсэл юм. Ийм учраас гэрээ нь маргаан үүсгэхгүй байхын тулд хууль зүйн хувьд хүчинтэй, хэл найруулгын хувьд нарийн, тогтолцоотой, тодорхой ойлгомжтой, тогтсон мэргэжлийн үг хэллэг хэрэглэх шаардлагатай байдаг.

Гэрээг талуудын оролцоо, агуулга, эрх зүйн үр дагавар, хэрэгжих хэлбэр зэргээс нь хамааран өөр өөрөөр ангилж үздэг. Ерөнхийдөө агуулгаас хамааран, ажил гүйцэтгэх, арилжаа, бизнес, хөрөнгө итгэмжлэх, хамтын ажиллагаа, түрээсийн гэрээ гэх мэтээр ангилдаг. Тухайлбал, “Бизнесийн гэрээ гэдэг нь тодорхой бизнесийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд харилцан эрх, үүргийг тогтоохоор хуульд заасан журмын дагуу иргэн эсвэл хуулийн этгээдүүдийн хооронд байгуулсан гэрээ бөгөөд уг гэрээ нь талуудын аль алинд нь хууль зүйн хүчин төгөлдөр, заавал биелүүлэх шинжтэй байна” (Xiangwen, 2013).

Бидний судалгааны хүрээ, зорилго бол дурдсан төрлийн гэрээний бичвэрийн хүрээнд хэл зүй, үгийн сангийн судалгаа хийхэд оршиж буй тул гэрээний үүсэл хөгжил, төрөл зүйлийн талаар дэлгэрэнгүй авч үзсэнгүй. Гэрээний хэл нь эрх зүйн баримт бичгийн хэлний нэг чухал салбар тул хуулийн хэл шинжлэл (legal linguistics), хууль зүйн дискурсын шинжилгээ, үүргийн хэл шинжлэл, хөмрөг хэл шинжлэл зэрэг чиглэлийн хүрээнд судалж, бүтцийн онцлог, хэл зүйн хэв шинж, үгийн сангийн бүрдэл, прагматик үүргийг тодорхойлсон бүтээлүүд нэлээд хийгджээ. Тухайлбал, гэрээний хэлэнд тодорхой байдал, нэг утгат чанар, стандартчилал, давтагдмал хэлбэр зонхилдог болохыг судлаачид онцолдог.

Түүнчлэн гэрээний нэр томьёоны тогтолцоо, түүний нэг мөр хэрэглээ, орчуулгын асуудлыг авч үзсэн бүтээл нэлээд бий. Ялангуяа олон улсын болон хоёр талт гэрээ, арбитрын баримт бичгийн хүрээнд нэр томьёоны дүйцэл, утгын зөрүү, хууль зүйн үр дагаварт үзүүлэх нөлөөг нарийвчлан авч үзсэн судалгаанууд хийгдсэн байна. Энэ хүрээнд гэрээний нэр томьёог зөвхөн хэлний нэгж бус, эрх зүйн ойлголтыг дамжуулагч танин мэдэхүйн хэрэгсэл хэмээн үзэх хандлага түгээмэл болжээ.

Монгол хэл шинжлэлийн судалгаанд гэрээний хэл нь төдийлөн судлагдаагүй, ихэвчлэн хууль зүйн баримт бичгийн хэл найруулга, албан бичгийн хэв маяг, нэр томьёоны хэрэглээ, орчуулгын асуудлыг ерөнхий түвшинд багтаан авч үзэж ирсэн бөгөөд гэрээний хэлний бүтэц, дискурсийн онцлог, үгийн сангийн онцлог, хэрэглээний утга зүйн (pragmatics) чиг үүргийг тусгайлан авч үзсэн судалгаа хараахан бичигдээгүй байна. Иймээс гэрээний хэлийг хэл шинжлэлийн онол, орчин үеийн судалгааны арга зүйтэй уялдуулан, нэр томьёо, бүтэц, утга, хэрэглээний түвшинд цогцоор нь судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ нь гэрээний баримт бичгийн ойлгомжтой байдал, эрх зүйн баталгааг

сайжруулахын зэрэгцээ хууль, эрх зүйн хэлний хөгжлийн онол, практикт бодитой хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Тиймээс бид энэхүү судалгаандаа гэрээний бичвэрийн хэл зүй, үгийн сангийн онцлог болон түгээмэл хэрэглэдэг үг хэллэгийн давтамжийг тооцоолж, жишээ баримт түшин задлан шинжлэхээр зорьсон билээ.

2. Судалгааны арга зүй

Судалгаанд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ашигладаг түрээс, хөдөлмөр, худалдаа, үйлчилгээ, хамтын ажиллагаа зэрэг төрөл бүрийн гэрээний үг хэллэгийн төлөөлөх чадварыг хангахын тулд зорилтот болон санамсаргүй түүврийн хосолмол аргаар нийт 84 жишиг гэрээний эхийг сонгож, “Sketch engine” хэл шинжлэлийн программ ашиглан хөмрөг бүрдүүлэв. Тус хөмрөг нь давтагдсан тоогоор 270745 буюу давтагдаагүй тоогоор 15198 үгтэй.

Энэхүү судалгааг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан гүйцэтгэсэн. Тоон судалгааны аргыг гэрээний эх бичвэр дэх үг хэллэгийн хэрэглээ, давтамж, бүтцийг тоон дүн шинжилгээнд тулгуурлан тодорхойлох зорилгоор хэрэглэв. Тодруулбал, тоон өгөгдлийг боловсруулахдаа давтамжийн шинжилгээг гэрээний хэллэгийн түгээмэл буюу түлхүүр үгсийг тодорхойлох; хувь хэмжээ, тархалтын шинжилгээ (distribution analysis)-г гэрээнд хэрэглэгдэх нэр томьёоны хувь хэмжээг тодорхойлох; харьцуулсан статистик шинжилгээг түгээмэл нэр томьёоны ялгааг тоон үзүүлэлтээр харьцуулахад тус тус хэрэглэв. Чанарын судалгааны аргыг гэрээний үг хэллэгийн үгийн сан-утга зүй, хэл зүй, найруулга зүйн онцлогийг тодруулах зорилгоор хэрэглэв. Тодруулбал, агуулга шинжилгээ (content analysis)-гээр гэрээний үг хэллэг, нэр томьёог ангилж, нийтлэг хэрэглээ, давтамж, утгын ялгааг тодорхойлов. Дискурс шинжилгээгээр гэрээнд хэрэглэж буй түгээмэл үг хэллэгийн хэрэглээг талуудын хариуцлага, эрх-үүргийн илэрхийлэлтэй холбон тайлбарлахыг оролдов.

3. Гэрээний хэл зүйн онцлог

Гэрээ бол хууль эрх зүйн баримт бичиг тул тогтсон хэл найруулга, стандарт бүтэцтэй байдаг. Гэрээний ерөнхий бүтцийг ажиглавал, дараах агуулгатай байна. Үүнд:

- Гэрээний нэр (гарчиг)
- Оршил (талуудын тухай мэдээлэл, эрх зүйн үндэслэл)
- Үндсэн заалт (эрх, үүрэг, нөхцөл, хугацаа, төлбөр, хариуцлага гэх мэт)
- Төгсгөл хэсэг (мөрдөх хугацаа, маргаан шийдвэрлэх журам, хүчин төгөлдөр болох нөхцөл)
- Талуудаар баталгаажуулах хэсэг (гарын үсэг, тамга) гэсэн бүтэцтэй.

Гэрээний хэл найруулга нь талуудын хооронд байгуулсан гэрээ, тохиролцоог боловсруулах, хэрэгжүүлэх үндсэн суурь бүтэц болдог. Энэ нь талуудын эрх,

үүрэг, хариуцлагыг тодорхойлж, ойлгомжтой болгодог бөгөөд маргаан гарах эрсдэлийг бууруулахад чиглэдэг. Иймээс гэрээний хэл найруулга зөв байх нь гэрээг хууль ёсны, хүчин төгөлдөр байлгах чухал нөхцөл юм.

“Гэрээ нь худалдаа, бизнес хэлэлцээрийн эрх зүйн суурь болж, оролцогч талуудын зорилго, үүрэг хариуцлагыг тусган илэрхийлдэг. Гэрээний хэлийг хэтэрхий хатуу тогтсон хэв загвартай гэж үздэг боловч гэрээний хэрэгжилтэд эрх зүйн үүрэг, ач холбогдол ихтэй, чухал нөлөөтэй байдаг. Гэрээг боловсруулах хэл, тухайлбал өгүүлбэр зүйн бүтэц, үгийн сангийн сонголт, мөн баймж шинж нь гэрээний заалтыг тодорхой юм уу эсвэл хоёрдмол утгатай болгох шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг (Tiersma, 1999: 55).

Гэрээ нь албан бичгийн найруулгын нэгэн төрөл тул уран яруу үг хэрэглэхгүй, үгийн сан, утга зүй, үг зүй, өгүүлбэр зүйн хувьд өвөрмөц онцлогтой. Тодруулбал, өгүүлбэр зүйн хувьд, гэрээний заалт, нөхцөлүүдийг бүрэн, тодорхой илэрхийлэхийн тулд нэг өгүүлбэрт олон тодотгол, нөхцөл оруулсан урт нийлмэл өгүүлбэр их хэрэглэдэг. Ихэвчлэн угсарсан нийлмэл өгүүлбэр зонхилдог. Жишээ нь: 1. “Энэ гэрээний хэрэгжилтэд талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд түүнийг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ”. 2. “Талуудын хооронд үл ойлголцол үүссэн тохиолдолд хэлэлцээрийн замаар шийдвэрлэнэ”. 3. “Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу нөхөн төлнө”. гэсэн гурван өгүүлбэр нь нөхцөл заасан байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр бөгөөд гишүүн өгүүлбэр нь нөхцөл илэрхийлж, гол өгүүлбэр нь шийдвэрлэх үйлдлийг илтгэж байна.

Түүнчлэн “Түрээслэгч нь гэрээний хугацаанд түрээсийн төлбөрийг сар бүрийн 5-ны дотор бүрэн төлнө”. Энэхүү өгүүлбэрт “түрээслэгч”, “түрээсийн төлбөр”, “гэрээний хугацаа” зэрэг нэр томьёо нь тодорхой эрх зүйн статустай ойлголтыг илэрхийлж байна. Ирээдүй цагийн төлнө үйл үг нь заавал биелүүлэх шинжийг илтгэж, хугацааг “5-ны дотор” хэмээн нарийвчлан заасан гэрээний хугацааг хязгаарлаж байна. Ийм бүтэц нь гэрээний заалтын норматив шинжийг тодруулдаг. Дээрх жишээнүүдээс харахад, хэл зүйн бүтцийн хувьд урт нийлмэл өгүүлбэр давамгайлж, нөхцөл заасан бүтэц, захирамжлах өнгө бүхий үйл үгс зонхилж байгаа нь гэрээний заалтыг тайлбарлах бус, гүйцэтгэх үүрэгтэй эрх зүйн акт болохыг илтгэж, гэрээний бичвэрийг норматив шинжтэй, маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хэлний тусгай хэрэглээ болохыг бататгана. Тухайлбал, өгүүлбэрийн өгүүлэхүүн болох үйл үг нь ихэвчлэн ирээдүй цагийн -на⁴ төгсгөлтэй байгаа нь заавал биелүүлэх шинжийг илэрхийлсэн хэлбэр болно. Үүнийг статистик тооцооллоос харвал, -на⁴ төгсгөлтэй 408 үйл үг 10344 удаа давтагдсан байна. Тухайлбал, зарим жишээг Зураг 1-д үзүүлсэн Sketch Engine программаар тооцоолсон байдлаас харж болно.

Word	Frequency	Word	Frequency	Word	Frequency	Word	Frequency	Word	Frequency
байна	999	11 гадна	62	21 тусана	31	31 тайлбарлана	16	41 алдана	10
байгуулна	155	12 явуулна	48	22 батална	29	32 бологсруулна	15	42 байлгана	9
ажиллана	152	13 хангана	46	23 хасна	26	33 шаврдана	14	43 гаргуулна	9
авна	116	14 заана	45	24 ажиллуулна	23	34 батлуулна	14	44 байршуулна	9
хариуцна	106	15 оруулна	43	25 зарцуулна	20	35 хаана	14	45 явагдана	9
зохицуулна	100	16 төвлөцүүлнэ	43	26 цуцална	20	36 зурна	13	46 хявардана	8
гаргана	89	17 ашиглана	39	27 барагдуулна	20	37 тайлагнана	13	47 суутгана	8
баталгаажуулна	88	18 хадгална	39	28 жагсаана	19	38 дурдана	12	48 шалгаруулна	8
хавсаргана	67	19 тавина	35	29 тодруулна	18	39 судална	11	49 баримтлана	7
хариулна	63	20 баримтална	33	30 хамварна	17	40 анхварна	11	50 урамшуулна	7

Зураг 1. Sketch Engine программаар -на⁴ төгсгөлтэй үйл үгийн давтамжийг харуулсан байдал

Тэдгээрээс хамгийн давтамжтай 10 үгийг хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 1.

№	-на ⁴ төгсгөлтэй үйл үгс	Давтамж	Жишээ
1	шийдвэрлэнэ	277	Талуудын хооронд үл ойлголцол гарсан тохиолдолд хэлэлцээрийн замаар <u>шийдвэрлэнэ</u> .
2	олгоно	248	Үнэ хаялцуулах ажиллагаа явагдаагүй буюу түүнд оролцоогүй, эсвэл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан <u>олгоно</u> .
3	төлнө	192	Зээл олгогчид жилийн 30 хувийн хугацаа хэтэрсэн хүү <u>төлнө</u> .
4	тооцно	174	4.2 Гэрээг цуцлах талаар аль нэг тал бичгээр санал гаргаагүй бол гэрээг хүчинтэйд <u>тооцно</u> .
5	өгнө	165	Шийдвэр гаргах дүүргийн шүүх шийдвэрээ үндэслэлтэйгээр гаргаж гомдол гаргаагчид <u>өгнө</u> .
6	хүлээнэ	158	2.2 Батлан даагч батлан даалтын гэрээнд заасан хэмжээгээр хариуцлага <u>хүлээнэ</u> .
7	байгуулна	155	Анзын гэрээг заавал бичгээр <u>байгуулна</u> .
8	ажиллана	152	Хамтын гэрээний биелэлтэд талууд болон тэдгээрийн төлөөлөгчид хяналт тавин <u>ажиллана</u> .
9	хариуцна	116	Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч <u>хариуцна</u> .
10	зохицуулна	100	Эргэн төлөх дүн, хугацааг гэрээгээр <u>зохицуулна</u> .

Хүснэгт 1-ээс харахад, гэрээний хэлэнд “-на⁴” төгсгөлтэй үйл үгсийг их давтамжтай хэрэглэж байгаа нь эрх зүйн бичвэрийн захирамжлах, үүрэгжүүлэх, заавал биелүүлэх шинжийг тодотгож байна. “шийдвэрлэнэ”, “олгоно”, “төлнө”, “тооцно”, “хариуцна”, “зохицуулна” зэрэг үйл үгс нь талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой, хоёрдмол утгагүй тогтоох үндсэн хэрэгсэл болж байна. Давтамжаар тэргүүлж буй эдгээр үг нь ихэвчлэн маргаан шийдвэрлэх, санхүүгийн үүрэг гүйцэтгэх, эрх зүйн үр дагавар тогтоох үйлдлийг илэрхийлж байгаа нь гэрээний гол зорилго болох харилцааг урьдчилан зохицуулах, зөрчил

үүсэхээс сэргийлэх чиг үүрэгтэй нийцэж байна. Мөн эдгээр үйл үг нь ирээдүйд заавал хэрэгжих үйлдлийг илтгэх тул гэрээний заалтуудыг хуульчилсан, хэм хэмжээ тогтоосон, объектив өнгө аястай болгож байна. Иймээс “-на” төгсгөлтэй үйл үгсийн хэрэглээ нь гэрээний хэлийг тогтвортой бүтэцтэй, стандартчилсан, захиран заах шинж давамгайлсан эрх зүйн тусгай хэл болохыг баталж байна. Энэ нь гэрээний эхийг тайлбарлахад ойлгомжтой, хэрэгжүүлэхэд маргаан багатай байх чухал нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж болно.

Бидний судалгаанаас үзэхэд, “тохиолдолд” гэдэг үг нийт 865 удаа тохиолдож байгаа бөгөөд тэдгээрийн 70% нь гэрээний нөхцөлийн зөрчлийг илэрхийлсэн хам сэдэвт *хангаагүй, зөрчсөн, зөвшөөрөөгүй, нотлоогүй, хэтэрсэн, гүйцэтгээгүй, цуцалсан, хүлээн аваагүй, маргаан үүссэн, боломжгүй, саад учруулсан, биелүүлээгүй, үл ойлголцол гарсан* зэрэг үгстэй тохиолдож байна. Жишээ нь:

- 1) Талуудын хоорондын маргаан үүссэн **тохиолдолд** хариуцагчийн байгаа газрын / шүүх/ -аар шийдвэрлэнэ.
- 2) Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй **тохиолдолд** гэрээнээс татгалзах эрхээ алдах болзолтойгоор гэрээ байгуулсан бол уг болзол бий болсон тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзах эрхтэй. (Гэрээний эрх зүй. х.77)

Үг зүйн хувьд үгсийн аймгаас хамгийн олон тохиолдож буй нь жинхэнэ нэр (*талууд, нөхцөл, хариуцлага* гэх мэт), үйл үг (*хүлээх, үүсэх* гэх мэт), холбох үгс (*хэрэв, болон, бөгөөд, эсвэл* гэх мэт), Үгийн аймгийн хэрэглээг давтамжаар тооцоолон үгийн аймаг тус бүрээс хамгийн их давтамжтай 10 үгийг хүснэгтлэн авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Жинхэнэ нэр

№	Нэр томьёо	Давтамж	Жишээ өгүүлбэр
1	талууд	3564	<i>Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.</i>
2	үүрэг	2833	<i>Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.</i>
3	гэрээний нөхцөл	2210	<i>Гэрээний ерөнхий нөхцөлд заасныг дагаж мөрдөнө.</i>
4	эрх	1299	<i>Нийлүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй гэж Захиалагч үзвэл төлбөрийг шилжүүлэхгүй байх эрхтэй.</i>
5	нөхөн төлбөр	964	<i>Худалдагч барааг гэрээний нөхцөлд нийцүүлэн нийлүүлээгүй тохиолдолд худалдан авагч нөхөн төлбөрийг төлөхийг шаардана.</i>
6	үйл ажиллагаа	586	<i>Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээнд заасан хүрээнд үйл ажиллагаагаа тасралтгүй, тогтмол явуулж, үйлчилгээний чанарыг хангана.</i>
7	хохирол	240	<i>Хэрэв Нийлүүлэгч дүр мэдэн гэрээнээс татгалзах бол үүнтэй холбогдон Захиалагчид учирсан шууд болон шууд бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.</i>
8	зардал	252	<i>Энэ үнэд НӨАТ бусад татвар, хураамж, барааг тээвэрлэх, хүргэх, шалгах зэрэг бүх зардал багтсан болно.</i>

9	давагдашгүй хүчин зүйл	170	<i>Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн долоо хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж болно.</i>
10	нийтлэг үндэслэл	64	<i>Энэхүү нэр томьёо нь гэрээний нэг бүрдэл хэсгийг нэрлэнэ.</i>

Хүснэгт 2-оос харахад, гэрээнд харилцагч талуудын байр суурь, эрх-үүргийг тодорхойлох, мөн эрсдэл, хариуцлагын зохицуулалтыг тогтоох чиг үүрэгтэй нэр томьёо давамгай хэрэглэгддэг нь ажиглагдаж байна. Юуны өмнө “талууд” (3564) гэсэн нэр томьёо хамгийн өндөр давтамжтай байгаа нь гэрээ нь хоёр ба түүнээс дээш этгээдийн эрх зүйн харилцааг зохицуулдаг баримт бичиг болохыг илтгэнэ. Энэ нэр томьёо нь гэрээний бүх зохицуулалтын суурь ойлголт болж, бусад эрх, үүрэг, хариуцлагын заалтуудыг холбох гол зангилаа үүрэг гүйцэтгэж байна. “Үүрэг” (2833) болон “эрх” (1299) гэсэн нэр томьёоны давтамж нь гэрээний хэлний үндсэн зорилго нь талуудын хүлээх үүрэг, эдлэх эрхийг нарийвчлан зааглах явдал болохыг нотолж, гэрээний тэнцвэрт байдлыг хангах үндэс болдог. “Гэрээний нөхцөл” (2210) гэсэн нэр томьёо нь гэрээний агуулгыг бүрдүүлэгч заалтуудыг ерөнхийд нь нэрлэж, ерөнхий болон тусгай нөхцөлийг ялган зохион байгуулахад чухал үүрэгтэй, гэрээний бүтцийн учир зүйг илэрхийлдэг суурь нэр томьёо юм. Харин “нөхөн төлбөр” (964), “хохирол” (240), “зардал” (252) зэрэг нэр томьёог талууд гэрээг зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагаврыг тодорхой болгох зорилготой хэрэглэдэг. Мөн “давагдашгүй хүчин зүйл” (170) гэх мэт нэр томьёо нь гэрээний хэрэгжилтэд талуудаас үл хамаарах нөхцөл байдлыг зохицуулж, эрх зүйн эрсдэлийг бууруулахад чиглэсэн тусгай утгатай ойлголтыг илэрхийлнэ. Харин “нийтлэг үндэслэл” (64) зэрэг харьцангуй бага давтамжтай нэр томьёо нь гэрээний тодорхой хэсэг, учир зүйн тайлбар зэргийг багтаасан туслах шинжтэй хэрэглээтэй байна.

Хүснэгт 3. Үйл үг

	Үйл үг	Давтамж	Жишээ өгүүлбэр
	байх	2797	<i>Энэхүү гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна.</i>
	болох	2398	<i>Энэхүү нөхцөл нь талуудын хувьд заавал биелүүлэх үүрэг болно.</i>
	заах	1566	<i>Төлбөр хийх хугацааг гэрээнд тодорхой заасан байна.</i>
	байгуулах	1438	<i>Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэхүү гэрээг байгуулна.</i>
	ажиллах	877	<i>Гүйцэтгэгч нь холбогдох дүрэм, стандартыг мөрдөн ажиллана.</i>
	шийдвэрлэх	782	<i>Гэрээтэй холбоотой маргааныг талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэнэ.</i>
	гүйцэтгэх	637	<i>Нийлүүлэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд бүрэн гүйцэтгэнэ.</i>
	хэрэгжих	560	<i>Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хэрэгжинэ.</i>
	ашиглах	553	<i>Захиалагч нь тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглана.</i>
	өгөх	354	<i>Гүйцэтгэгч ажлыг гэрээнд заасан хугацаанд захиалагчид хүлээлгэн өгнө.</i>

Хүснэгт 4-т буй үйл үгс нь гэрээний хэлний үүргийн цөм болж, эрх зүйн харилцааг тогтоох – үүрэгжүүлэх – хэрэгжүүлэх – хянах гэсэн учир зүйн дарааллыг бүрдүүлж байна. Их давтамжтай эдгээр үйл үг нь гэрээний хэлний стандарт, хэвшмэл шинжийг илэрхийлж, гэрээг ойлгомжтой, маргаан багатай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хүснэгт 5. Холбох үг

	Холбох үг	Давтамж	Жишээ өгүүлбэр
1	болон	2275	Талуудын эрх болон үүргийг энэхүү гэрээгээр тодорхойлно.
2	дагуу	924	Гүйцэтгэлийг гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ.
3	тухай	833	Талууд маргаан шийдвэрлэх тухай дараах байдлаар тохиролцов.
4	ба	723	Захиалагч ба Гүйцэтгэгч дараах үүргийг хүлээнэ.
5	буюу	432	Давагдашгүй хүчин зүйл, буюу талуудаас үл хамаарах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэхүү заалтыг баримтална.
6	бөгөөд	478	Энэхүү гэрээ нь хоёр хувь үйлдэгдсэн бөгөөд талууд тус бүр нэг хувийг хадгална.
7	талаар	470	Талууд төлбөрийн нөхцөлийн талаар харилцан тохиролцов.
8	эсхүл/эсвэл	272/308	Маргааныг шүүх эсхүл арбитрын журмаар шийдвэрлэнэ.
9	тул	78	
10	боловч	76	

Хүснэгт 5-д гэрээний хэлэнд хэрэглэдэг эдгээр холбох үг нь өгүүлбэр буюу гэрээний заалт хоорондын логик уялдаа, утгын нарийвчлал, эрх зүйн тодорхой байдлыг хангах гол хэрэгсэл болдог. “Болон”, “ба” зэрэг нэмэх утгатай холбох үгс нь гэрээний бүтэц, бүрэлдэхүүнийг зохион байгуулдаг бол “дагуу”, “тухай”, “талаар” нь зохицуулалтын суурь, хамрах хүрээг тогтоодог. Харин “эсхүл/эсвэл”, “тул”, “боловч” зэрэг нь нөхцөл, сонголт, эсрэгцлийг илэрхийлж, гэрээний хэлний нарийн логик бүтэц бүрэлдэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Хязгаарлалт, нөхцөл заасан, “хэрэв”, “тохиолдолд”, “эсхүл”, “гэвч” гэх мэт нөхцөлдүүлэн холбох үг өргөн хэрэглэдэг. Тухайлбал, бидний судалгааны хөмрөгт “хэрэв” “тохиолдолд” хэмээх үг 865 тохиолдож байна.

Хүснэгт 6. Төлөөний үг

	Төлөөний үг	Давтамж	Жишээ өгүүлбэр
1	энэ / энэхүү	867/745	Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна.
2	бусад	945	Гэрээнд заасан болон бусад холбогдох зардлыг Нийлүүлэгч хариуцна.
3	тухайн	745	Тухайн нөхцөл байдалд холбогдох шийдвэрийг Захиалагч гаргана.
4	дараах	639	Талууд дараах нөхцөлийг харилцан зөвшөөрөв.
5	тус	437	Тус гэрээний хэрэгжилтэд талууд хамтран хяналт тавина.
6	аль	343	Аль тал үүргээ зөрчсөнийг гэрээнд заасан журмаар тогтооно.

7	нөгөө	306	Нэг тал үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
8	уг	291	Уг нөхцөл нь гэрээний салиггүй хэсэг болно.
9	аливаа	264	Аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
10	өөр	204	Талууд харилцан тохиролцсоноор өөр нөхцөл тогтоож болно.

Хүснэгт 6-аас харвал, гэрээний хэлэнд хэрэглэгддэг эдгээр төлөөний үг нь өмнө дурдсан ойлголт, этгээд, заалтыг давтан нэрлэхээс зайлсхийж, бичвэрийн нэгдмэл байдал, утгын нарийвчлал ба логик уялдааг хангах, мөн заалтын хамрах хүрээг зохистой тэнцвэржүүлэх үндсэн үүрэг гүйцэтгэж байна. “Энэ/энэхүү”, “тус”, “уг” зэрэг нь тодорхой заалтыг баталгаажуулдаг бол “бусад”, “аливаа”, “өөр” зэрэг нь ерөнхий, нээлттэй хүрээг бүрдүүлж, гэрээний хэлний хэм хэмжээ, албаны шинжийг хангахад чухал ач холбогдолтой юм.

Хүснэгт 7. Орон цагийн нэр

	Орон цагийн нэр	Давтамж	Жишээ өгүүлбэр
1	дээр	462	<i>Дээр</i> дурдсан нөхцөлийг талууд заавал мөрдөнө.
2	цаашид	336	Талууд цаашид харилцан итгэлцлийн үндсэн дээр хамтран ажиллана.
3	дотор	307	Төлбөрийг гэрээнд заасан өдрөөс хойш 10 хоногийн дотор шилжүүлнэ.
4	өмнө	295	Ажлыг эхлүүлэхээс өмнө талууд харилцан зөвшилцөнө.
5	хойш	216	Гэрээ дуусгавар болсноос хойш 30 хоногийн дотор тооцоо хийнэ.
6	дээш	161	Саатал 7 хоногоос дээш үргэлжилбэл гэрээг цуцалж болно.
7	дараа	146	Саатал 7 хоногоос дээш үргэлжилбэл гэрээг цуцалж болно.
8	хооронд	115	Гэрээний хэрэгжилтийг 2025–2026 оны хооронд хангана.
9	түр	89	Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гэрээний хэрэгжилтийг түр зогсоож болно.
10	даруй	83	Зөрчил илэрсэн тохиолдолд Захиалагчид даруй мэдэгдэнэ.

Хүснэгт 7-оос харахад, гэрээний хэлэнд орон, цагийн нэрс нь үйлдэл, үүрэг, эрх зүйн үр дагавар хаана, хэзээ, ямар хугацаанд, ямар дарааллаар хэрэгжихийг тодорхойлох үндсэн хэрэгсэл болж байна. Эдгээр нь гэрээний заалтыг тодорхой, хэмжигдэхүйц, маргаангүй болгох чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, эдгээр орон, цагийн нэр нь гэрээний заалтыг цаг хугацаа, орон зайн хувьд нарийвчлан тогтоож, үүргийн хэрэгжилтийг тодорхой болгох замаар маргаан үүсэх эрсдэлийг бууруулдаг. “Дотор”, “өмнө”, “хойш”, “дараа” зэрэг нь хугацааны логик дарааллыг тогтоодог бол “цаашид”, “түр”, “даруй” нь гэрээний үргэлжлэх байдал, яаралтай шинжийг илэрхийлж, гэрээний хэлний нарийн зохион байгуулалт, албаны шинжийг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Хүснэгт 8. Тэмдэг нэр

	Тэмдэг нэр	Давтамж	Жишээ өгүүлбэр
1	бүрэн	350	Нийлүүлэгч нь ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгэх үүрэгтэй.
2	тодорхой	339	Гэрээнд төлбөрийн нөхцөлийг заасан тодорхой заалт тусгасан байна.
3	ерөнхий	221	Гэрээний ерөнхий нөхцөлийг энэ бүлэгт заана.
4	аюулгүй	181	Ажлыг гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны дүрмийг сайтар баримтална
5	нийтлэг	155	Талууд дараах нийтлэг үүргийг хүлээнэ.
6	дотоод	153	Энэхүү заалт нь талуудад нийтлэг үйлчилнэ.
7	үнэт	113	Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэхдээ зохиогчийн нэрийг өөрчлөх эрхгүй.
8	бодит	73	Учирсан бодит хохирлыг нөхөн төлнө.
9	тогтмол	69	Талуудын тогтмол харилцааг гэрээгээр зохицуулна.
10	бүтээлч	47	Ажлыг бүтээлч байдлаар гүйцэтгэхийг зорино.

Хүснэгт 8-аас харахад, гэрээний хэлэнд хэрэглэдэг эдгээр тэмдэг нэр нь нэр үг, нэр томьёоны утгыг нарийсгах, баталгаажуулах, ангилах замаар гэрээний заалтыг ойлгомжтой, хэрэгжихүйц болгодог. “Бүрэн”, “тодорхой”, “бодит”, “тогтмол”, “аюулгүй” зэрэг нь эрх зүйн тодорхой, баталгаат, найдвартай байдлыг илэрхийлдэг бол “ерөнхий”, “нийтлэг”, “дотоод” зэрэг нь зохицуулалтын хамрах хүрээ, түвшнийг ялган тогтоож, гэрээний хэлний стандартчилсан, албаны шинжийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гэрээ нь хууль, эрх зүйн баримт бичиг тул баймж үгийг уран зохиол, сонин нийтлэлийн найруулгыг бодвол, харьцангуй бага хэрэглэдэг. Монгол хэлний баймж үгсийг “Үг болон өгүүлбэрийн утга санааг нэмэн дэлгэрүүлэх үүрэг бүхий баймж үг нь өгүүлж буй санааг улам эрчимжүүлсэн, лавшруулсан, баталсан, тодотгосон, лавлан онцолсон, эргэлзсэн, асуусан, үгүйсгэсэн, таамагласан, болгоомжилсон, хүч нэмэгдүүлсэн (Мөнх-Амгалан, 1998) гэх мэтээр ангилдаг. Бидний судалгаанаас үзэхэд, гэрээний баримт бичигт баймж үгээс өгүүлж буй санааг улам эрчимжүүлсэн, баталсан, тодотгосон, үгүйсгэсэн, хүч нэмэгдүүлсэн *маш, нэн, зөвхөн, гагцхүү, заавал, зайлиггүй* зэрэг баймж үгсийг үүрэг хариуцлагыг тодотгох, хүч нэмэгдүүлэх, эрх хэмжээний хүрээ хязгаарыг тодорхойлох зорилгоор хэрэглэж байна. Бид судалгааны хөмрөгөөс хамгийн түгээмэл хэрэглээтэй 10 баймж үгийг давтамжаар нь жагсаан Хүснэгт 9-д үзүүлээ.

Хүснэгт 9. Баймж үг

	Баймж үг	Давтамж	Жишээ өгүүлбэр
1	бус	165	Гүйцэтгэгчийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус магадлан хяналтад аливаа саад учруулахыг хориглоно.
2	үл	152	Талуудын хооронд үл ойлголцол гарсан тохиолдолд хэлэлцээрийн замаар шийдвэрлэнэ.

3	зөвхөн	105	Энэ гэрээний нөхцлийг зөвхөн хоёр талын бичгээр үйлдсэн тохиролцооны үндсэн дээр өөрчилнө.
4	нэн	98	Гэрээний үүргээ зөрчсөн тал уг зөрчлийг нэн даруй арилгана.
5	ёстой	92	Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой .
6	заавал	75	Арбитрын шийдвэр Талуудад эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэр байна.
7	зайлшгүй	47	Барилгын зураг, төсөв, бусад зайлшгүй шаардлагатай баримт бичиг, тоног төхөөрөмж, материал, эд зүйлийг хугацаанд нь гүйцэтгэгчид шилжүүлэн өгнө.
8	эс	30	Харилцагчийн буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас өөрт болон бусдад учирсан хохирлыг хариуцна.
9	маш	20	Захиалагч тээвэрлэлтийн ажлын шаардлагаас үндэслэн Ажил гүйцэтгэгчид маш тодорхой захиалга, даалгавар, төлөвлөгөө, эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг тодорхой цагт өгч байх гол үүрэгтэй
10	ямагт	18	Ажилтанд эзэмшсэн боловсрол, мэргэжил, мэргэшлийн төвишин, ур чадвараа дээшлүүлэх хичээл, сургалт болон бусад арга хэмжээнд хамрагдах бололцоог гаргаж өгөхөд ямагт анхаарах үүрэгтэй.

Дээрх хүснэгтүүд дэх хамгийн их давтамжтай үгсийг үгсийн аймгаар жагсаавал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 9.

№	Үгийн аймаг	Давтамж	Хувь
1	Нэр үг	12182	4.5
2	Үйл үг	11962	4.4
3	Холбох үг	6869	2.5
4	Төлөөний үг	5786	2.1
5	Орон цагийн нэр	2210	0.8
6	Тэмдэг нэр	1701	0.6
7	Баймж үг	802	0.2
			15.1

Гэрээний бичвэрт тооны нэрийг гэрээний нөхцөл, үүрэг, хариуцлага, мөнгөн дүн, хугацаа болон хэмжээг нарийвчлан заахад хэрэглэсэн байна. Тооны нэрийг бусад үгийн аймгийн адил давтамжаар тооцоолоход бэрхшээлтэй байсан тул түүний үүргийг тоймлон тодорхойллоо. Үүнд:

- Мөнгөн дүн, төлбөрийн хэмжээг заах: *Зээлдэгч нь үндсэн төлбөр 10,000,000 төгрөгийг гэрээнд заасан хугацаанд төлнө.* гэх мэтээр гэрээнд бараа, ажил үйлчилгээний үнэ, түрээсийн төлбөр, торгууль, хүү зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдийг тодорхой заахад хэрэглэнэ.
- Хугацаа, хугацааны хязгаар, үргэлжлэх хугацааг заах: *Түрээсийн гэрээний хугацаа 12 сарын турш хүчинтэй байна.* гэх мэтээр гэрээ хүчинтэй байх хугацаа, төлбөр хийх хугацаа, үүрэг биелүүлэх хугацааг нарийвчлахад хэрэглэнэ.

- Хэмжээ, тоо ширхэг, хэмжээст үзүүлэлт *Нийлүүлэх материал: 500 ширхэг шил, 200 кг цемент.* гэх мэтээр бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, материалын хэмжээг нарийвчлан заахад хэрэглэнэ.
- Хүү, хувь, индекс, торгууль зэрэг санхүүгийн үзүүлэлт: *Хугацаа хэтэрсэн зээлд 30% хүү тооцно.* гэх мэтээр санхүүгийн нөхцөл, өр төлбөр, торгуулийн хэмжээг нарийвчлан заахад хэрэглэнэ.

Тоон шинжилгээний үр дүнгээс харахад, гэрээний хэлэнд нэр үг, үйл үг, холбох үгс зонхилж байгаа бөгөөд “талууд”, “эрх”, “үүрэг”, “нөхөн төлбөр”, “давагдашгүй хүчин зүйл” зэрэг нэр томьёо нь гэрээний утга зүйн цөмийг бүрдүүлж байна. Харин “болон”, “эсхүл”, “дагуу” зэрэг холбох үгс нь заалтуудын логик уялдаа, сонголт, харьяаллыг тодорхой болгож, “дотор”, “дараа”, “дээр” зэрэг орон-цагийн нэрс нь гэрээний хэрэгжилтийн цаг хугацаа, орон зайн хүрээг нарийвчлан тогтоодог. Эдгээр түгээмэл үг хэллэг нь тухайн гэрээний төрлөөс үл хамааран тогтвортой давтагдаж, тусгай хэлний нэгэн хэв маягийг бүрдүүлдэг. Түүнчлэн *хянан шийдвэрлэх, зохион байгуулах, харилцан тохиролцох, өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах, гэрээ байгуулах, хяналт тавих, хариуцлага хүлээх, хамтран ажиллах, үүрэг хүлээх, үүрэг биелүүлэх, үүрэг зөрчих, хүлээн авах, хохирлыг барагдуулах, шаардлага хангах* гэх мэт холбоо үгийг давтамжтай хэрэглэсэн байна.

4. Гэрээний үгийн сангийн онцлог, хэрэглээ

“Аливаа хэлний үгийн санг хэрэглэгдэх хэмжээгээр нь идэвхтэй, идэвхгүй үгийн сан гэж ангилан үздэг бөгөөд албан бичигт идэвхтэй үгийн санд хамаарах үгийг хэрэглэдэг. Ингэснээрээ албан бичиг нийтэд ойлгомжтой байх шаардлага хангадаг...Албан бичигт хэрэглэгдэх үгийн тоо харьцангуй цөөн, давтагдан хэрэглэгдэх үгийн тоо олон байдаг” (Сүхбаатар, 2002: 183). Гэрээ нь албан бичгийн найруулгын төрөлд багтах тул хэрэглэх үгийн тоо харьцангуй цөөн боловч давтамжтай, тогтсон хэв маягтай. Судалгаанаас үзэхэд, гэрээний үгийн сан нь үүсвэр бүрэлдэхүүний хувьд уугуул үг, харь үгээс; найрлага бүрэлдэхүүний хувьд бичгийн хэлний үг, түүн дотроо хуучин болон шинэ үг, нэр томьёо болон мэргэжлийн үгээс бүрдэж байна.

Гэрээний үгийн сангийн бүрэлдэхүүнд нэр томьёо хамгийн гол байр суурь эзэлдэг нь эрх зүйн баримт бичгийн нэг хэлбэр болохыг батална. “Нэр томьёо гэдэг нь тодорхой нэг шинжлэх ухааны салбарт юм, үзэгдлийн тухай мэдлэгийн нэгж ухагдахууныг тэмдэглэсэн, тусгай үүрэгтэй үг”(Мөнхцэцэг, 2020: 17). Гэрээний нэр томьёо гэдэг нь хууль ёсны баримт бичигт оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох зорилгоор хэрэглэдэг тусгай хэллэг, үгсийн цогцыг хэлнэ. Гэрээний нэр томьёо нь нөхцөл, баталгаа, илэрхийлэл зэрэг ойлголтыг багтааж, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлдог бөгөөд давтамжийн жагсаалтаас харахад, “талууд”, “эрх, үүрэг”, “хариуцлага”, “хугацаа”,

“нөхцөл”, “төлбөр” “торгууль”, “алданги”, “маргаан” гэх мэт үг, нэр томьёо их давтамжтай байгаа нь гэрээний үндсэн агуулгыг бүрдүүлэгч ойлголтыг илэрхийлж, гэрээний бичвэр нь эрх зүйн харилцааг тогтоох, зохицуулахад чиглэдгийн баталгаа болж байна. “Эрх” хэмээх нэр томьёо нь “эдлэх”, “хүлээх”, “олгогдох” зэрэг үйл үгтэй, харин “үүрэг” нэр томьёо нь “хүлээх”, “биелүүлэх”, “зөрчих” зэрэг үйл үгтэй тогтмол хам хэрэглэгдэж байна. Жишээ нь: *Хууль, тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.* Энэ нь нэр томьёо дангаар орших бус, тогтсон хэл зүйн орчинд утгаа бүрэн илэрхийлдэг болохыг харуулж байна. Нэр томьёо нь энд зөвхөн хэлний нэгж бус, тодорхой эрх зүйн ойлголт, харилцааг дамжуулагч танин мэдэхүйн хэрэгсэл болдог. Эдгээр нэр томьёог зөв ойлгох нь бүх тал хүлээсэн үүргийнхээ утга агуулгыг тодорхой мэдэж, ингэснээр маргаан гарах, үл ойлголцох эрсдэлийг бууруулах ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, гэрээний нэр томьёог зөв, тодорхой илэрхийлэх нь гэрээ боловсруулах, хэрэгжүүлэхэд нэн чухал. Гэрээний нэр томьёо нь хууль зүйн тогтолцоо, гэрээний төрөл зэргээс хамааран нэлээд ялгаатай байж болох бөгөөд оролцогч талуудыг нэрлэсэн эсрэгцсэн нэр томьёо түгээмэл хэрэглээтэй байна. Тэдгээрийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 10. Эсрэгцсэн нэр томьёо

	Гэрээний төрөл	Эсрэг нэр томьёо
1	Ажил гүйцэтгэх	<i>гүйцэтгэгч ≠ гүйцэтгүүлэгч; ажиллуулагч ≠ ажиллагч</i>
2	Худалдаа	<i>худалдагч ≠ худалдан авагч</i>
3	Түрээс	<i>түрээслэгч ≠ түрээслүүлэгч; түрээслүүлэгч ≠ түрээслэн авагч; хөлслөгч ≠ хөлслүүлэгч</i>
4	Зуучлал	<i>зуучлагч ≠ зуучлуулагч</i>
5	Хөдөлмөр	<i>ажил олгогч ≠ ажилтан</i>
6	Зээл	<i>зээлдүүлэгч ≠ зээлдэгч/ зээл авагч</i>
7	Барьцаа	<i>барьцаалуулагч ≠ барьцаалагч</i>
8	Тээвэр	<i>тээвэрлэгч ≠ тээвэрлүүлэгч</i>
9	Итгэмжлэл	<i>итгэмжлэгч ≠ итгэмжлүүлэгч; төлөөлөгч ≠ төлөөлүүлэгч</i>
10	Даатгал	<i>даатгагч ≠ даатгуулагч</i>
11	Захиалга, үйлчилгээ	<i>захиалагч ≠ хөлсөөр ажиллагч;</i>
12	Бараа нийлүүлэлт	<i>үйлчлүүлэгч ≠ нийлүүлэгч; хүлээн авагч ≠ нийлүүлэгч</i>
13	Өмчлөл	<i>өмчлөгч ≠ хариуцан хамгаалагч</i>
	Бэлэглэл	<i>бэлэглэгч – бэлэг хүлээн авагч</i>

Дээрх хүснэгтээс харвал, гэрээний үгийн санд -гч дагавартай нэр томьёо онцгой байр суурь эзэлж байна. Эдгээр нь үйл үгийн язгуураас үүсэж, тодорхой этгээдийн эрх зүйн статустай холбоотой ойлголтыг илэрхийлдэг онцлогтой. . Өөрөөр хэлбэл, гэрээний бичвэрт үүрэг гүйцэтгэх этгээдийг тодорхойлж, үгийн утга, үүргийг нарийвчлахад “-гч” дагавар чухал үүрэг гүйцэтгэдэг. Жишээлбэл, “түрээслэгч”, “түрээслүүлэгч”, “гүйцэтгэгч”, “захиалагч”, “нийлүүлэгч”, “ажил

олгогч” зэрэг нэр томьёо нь тухайн этгээдийн гэрээний хүрээнд хүлээх эрх, үүргийг шууд нэрлэж, тэдгээрийг бусад оролцогчоос ялган таних хэрэгсэл болдог.

Нэг гэрээнд “түрээслүүлэгч” болон “түрээслэгч” гэх мэт нэр томьёог тогтмол, нэг мөр хэрэглэснээр аль тал ямар үүрэг хүлээж буй нь ойлгомжтой болно. *Нэг үг хэрэглэсэн бол түүнийг тууштай хэрэглэнэ. Худалдах худалдан авах гэрээнд “бараа бүтээгдэхүүн” гэсэн нэр томьёог хэрэглэсэн бол энэ үгээ гэрээний туршид хэрэглэнэ. Харин нэг бол “бараа бүтээгдэхүүн” эсвэл “эд зүйлс” гэж нэрлэж хоёр нэр томьёогоор нэг утгыг гаргах гэж оролдсны хэрэггүй. Тууштай байх нь дахин давтахаас илүү чухал. Гэрээг уншихад сонирхолтой байлгахад бус харин өмгөөлөгч таны гэрээний хоёрдмол санааг яаж ч ашиглаж болох юм гэдэгт анхаарах нь зүйтэй.* (Хууль зүйн зөвөлгөө, 2024). Хэдийгээр бидний судалгааны хэрэглэгдэхүүнд нэг гэрээнд нэг ухагдахуун буюу субъектыг өөрөөр нэрлэсэн тохиолдол байхгүй боловч зарим гэрээнд тогтсон нэр томьёоноос өөр хэлбэртэй нэр томьёог хэрэглэх үзэгдэл нэлээд байна. Жишээ нь: *зээлдүүлэгч, зээлдэгч* гэсэн тогтсон нэр томьёо байхад *зээл өгөгч/зээл олгогч, зээл авагч* гэж; *гүйцэтгүүлэгч, гүйцэтгэгч* гэсэн нэр томьёо байхад *ажиллуулагч, ажиллагч* гэж; *түрээслүүлэгч, түрээслэгч* гэсэн нэр томьёо байхад *түрээслэн өгөгч, түрээслэн авагч* гэж тус тус хэрэглэсэн байна. Түүнчлэн *нийтлэг үндэслэл* гэсэн тогтсон нэр томьёоны оронд зарим гэрээнд *нийтлэг заалт* гэж өөр нэр томьёо хэрэглэсэн тохиолдол байна. Тиймээс хууль зүйн нэр томьёоны журамласан толь бичигт эдгээрийг нэг мөр болгон журамлах шаардлагатай байна.

Хууль зүйн хийсвэр ойлголтыг илэрхийлсэн үгс (*хариуцлага, баталгаа, нөхцөл, үүрэг*) зонхилж байгаа нь гэрээний хэлний ерөнхий шинжийг тодорхойлж байна. Ийм хийсвэр нэр томьёо нь бодит үйл ажиллагааг шууд заахаас илүүтэйгээр тухайн үйлдлийн эрх зүйн үр дагавар, хариуцлагын хүрээг тогтоох үүрэгтэй. Жишээлбэл, “хариуцлага” гэх нэр томьёо нь зөрчил гарсан тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаврыг бүхэлд нь хамарч, тодорхой нэг үйлдлээр хязгаарладаггүй.

Гэрээ нь албан бичгийн найруулгын нэг төрлийн хувьд үгийн сан нь гарлын хувьд монгол хэлний уугуул үгс эзэлдэг.

Монгол албан бичгийн үгийн санг гарлын үүднээс авч үзвэл, ихэнх хэсгийг монгол хэлний үгийн үндсэн сангийн үгс эзэлдэг. Гадаад хэлнээс зээлдэн авч, орчин цагийн монгол хэлний үгийн санд оруулсан утга зохиолын хэлний хэм хэмжээний дагуу хэрэглэж байгаа хийгээд нэр томьёоны үүргээр хэрэглэж буй харь үг эл найруулгад голдуу тохиолдоно. Албан бичигт буй харь үгийн ихэнхийг ажил мэргэжлийн /прокурор, арбитр.../, цол зэргийн /профессор, доктор, офицер.../, үйлдвэр, байгууллага, түүний хэсэг салбарын /фабрик, завод, институт, театр, бригада.../, хэмжлийн нэр /метр, килограмм, гэх мэт/ эзэлдэг байна. (Сүхбаатар, 2002: 183).

Бидний судалгааны хэрэглэгдэхүүнд 105 гадаад үг 4379 удаа тохиолдож байна. Энэ нь гэрээний нийт үгийн 2.8%-ийг эзэлж байна. Тэдгээрийн дотор олон улсын шинжтэй нэр томъёог идэвхтэй хэрэглэж байгааг Хүснэгт 11-ээс харж болно. Давтамж ихтэй хэрэглэж буй 10 гадаад үгийг хүснэгтээр жагсаавал дараах байдалтай байна.

Хүснэгт 11. Гэрээний бичвэрт түгээмэл хэрэглэсэн гадаад үгсийн давтамж

№	Гадаад үг	Давтамж	Жишээ өгүүлбэр
1	компани	438	Энэхүү гэрээг “А” компани болон “Б” компани харилцан зөвшилцөж байгуулна.
2	банк	385	Төлбөрийг гэрээнд заасан хугацаанд ажил гүйцэтгэгчийн нэр дээрх Хаан банкны 5076899999 дансанд шилжүүлнэ.
3	арбитр	267	Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд арбитраар эцэслэн шийдвэрлэнэ.
4	стандарт	239	Нийлүүлэх бараа нь холбогдох үндэсний болон олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.
5	техник	214	Түрээслүүлж буй тоног төхөөрөмж нь ашиглалтын техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.
6	лиценз	210	Талууд гэрээнд заасан хүрээнд программ хангамж ашиглах лицензийг түрээслэгчид олгоно.
7	индекс	197	Түрээсийн төлбөрийг инфляцын албан ёсны индекс тэй уялдуулан жил бүр шинэчилнэ.
8	материал	189	Барилга угсралтад ашиглах материал нь батлагдсан техникийн баримт бичигт нийцсэн байна.
9	технолог	178	Гэрээний дагуу нэвтрүүлэх технолог нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх шаардлагатай.
10	инновац	157	Энэхүү төсөл нь үйлдвэрлэлийн инновацыг дэмжих зорилготой хэрэгжинэ.

Хүснэгт 11-ээс харвал, гэрээний хэлэнд хэрэглэж буй гадаад үгс нь ихэвчлэн эдийн засаг, санхүү, бизнес, техник-технолог, эрх зүйн маргаан шийдвэрлэх салбарт хамаарах нэр томъёо давамгайлж байгаагаараа онцлог байна. “компани”, “банк” зэрэг үгс давтамж их байгаа нь гэрээний харилцаа зах зээлийн эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаатай салшгүй холбоотойг илтгэнэ. Харин “арбитр” хэмээх үгийн идэвхтэй хэрэглээ нь маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх олон улсын болон дотоодын эрх зүйн практик гэрээний хэлэнд туссаныг харуулж байна. Мөн “стандарт”, “техник”, “лиценз”, “технолог”, “инновац” зэрэг үгийн давтамж харьцангуй их байгаа нь гэрээний агуулга зөвхөн эрх, үүргийг тогтоохоос гадна чанар, шаардлага, норм, зөвшөөрөл, технологийн түвшинг тодорхойлох чиглэлд өргөжиж байгааг нотолж байна. Гэрээний бичвэр дэх гадаад үгийн хэрэглээ нь орчин үеийн гэрээний хэл шинжлэх ухаан, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжилтэй уялдан олон улсын шинжтэй, мэргэжлийн түвшинд стандартчилагдсан шинжтэй болж буйг илтгэнэ. Гэрээний бичвэрт хэрэглэж буй гадаад үгсийг утга, үүргээр нь авч үзвэл, хэд хэдэн бүлэгт ангилж болохоор байна.

Нэгдүгээрт, эдийн засаг, санхүүгийн харилцааг илэрхийлэх “банк”, “лизинг”, “депозит”, “баланс”, “франчайз”, “тариф”, “фидуц”, “бартер”, “кастадион” зэрэг гадаад үг нь худалдах худалдан авах, түрээс, барьцаа, өмчлөл, зээлийн гэрээ зэрэгт түгээмэл хэрэглээтэй байна. Ийм үгс нь гэрээний заалтыг ойлгомжтой, хэрэгжихүйц болгоход чухал үүрэгтэй бөгөөд ялангуяа зээл, түрээс, худалдах, худалдан авах гэрээнд их давтамжтай тохиолддог. Жишээ нь: *Талууд энэхүү гэрээний хүрээнд мөнгөн төлбөрийн оронд **бартерийн** хэлбэрээр, өөрөөр хэлбэл бараа, ажил, үйлчилгээ солилцох замаар харилцан үүргээ биелүүлэхээр тохиролцов. Түрээслэгч төлбөрийг сар бүрийн сүүлийн өдөр түрээслүүлэгчийн Хаан **банкны** ... дансанд шилжүүлнэ.*

Хоёрдугаарт, техник, технологи, стандарттай холбоотой “стандарт”, “техник”, “технологи”, “лиценз”, “реквизит”, “индекс”, “патент” зэрэг үг нь гэрээний объектыг нарийвчлан тодорхойлох үүрэгтэй. Эдгээр нэр томьёо нь тухайн бараа, ажил, үйлчилгээний чанар, шаардлагыг олон улсын болон салбарын түвшинд тогтоох, гэрээний агуулгыг илүү нарийн, тодорхой болгох үүрэгтэй байна. Жишээ нь: *Монгол Улсын холбогдох **стандарт** болон барааны тодорхойлолтод нийцсэн бараа, түүхий эдийг худалдан авагчид нийлүүлнэ. Өрөмдлөгийн ажлыг өрөмдлөгийн **технологи**, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд баримтлан чанартай, хурдан шуурхай, геологи өрөмдлөгийн ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэнэ.*

Гуравдугаарт, аж ахуй, бизнесийн оролцогчдыг нэрлэх “компани”, “дилер”, “менежер”, “дистрибьютер”, “субдистрибьютер”, “брокер” зэрэг гадаад үг нь зах зээлийн харилцаанд тогтсон ойлголтыг илэрхийлж, талуудын статус, үүргийг ялган заахад хэрэглэж байна. Жишээ нь: ***Дистрибьютер** нь Бэлтгэн нийлүүлэгчийн урьдчилан эрх олгосноос бусад тохиолдолд түүний нэрийн өмнөөс эсвэл түүний эрх ашгийн тулд ажиллах эрхгүй. Худалдагч талын **брокер** нь худалдагч этгээдийн гэрээнд тусгасан мэдээллийн үнэн зөв байдалд баталгаа өгч, хариуцлага хүлээнэ.*

Дөрөвдүгээрт, хууль эрх зүй, маргаан шийдвэрлэхтэй холбоотой “акт”, “конвенц”, “статус”, “арбитр”, “юрисдикц” зэрэг үгийг гэрээний хэрэгжилт, маргааныг шийдвэрлэх механизмыг тодорхойлоход хэрэглэжээ. Жишээ нь: *Талуудын хоорондын маргаан үүссэн тохиолдолд хариуцагчийн байнга газрын шүүх, **арбитраар** шийдвэрлэнэ. Худалдагч эд хөрөнгө, түүнтэй холбоотой бичиг баримтыг гэрээний 3.1-д заасан төлбөр бүрэн төлөгдсөнөөс хойш ажлын 5 өдрийн дотор **акт** үйлдэж шилжүүлнэ.*

Гэрээний бичвэр дэх гадаад үгийн хэрэглээтэй холбоотой ажиглагдсан нэг зүйл бол орчуулж болох зарим гадаад үгийг орчуулаагүй, галиглан буулгахдаа олон янзаар бичсэн гэх мэт анхаарвал зохих зүйл нэлээд байна. Жишээ нь: *дистрибьютер / дистрибьютор / дестрибьютор; франчайз / франчиз /франчаиз; фидуци / фидуц гэх мэт олон хувилбартай бичиж байна. Зүй нь, **дистрибьютер** гэхийн оронд **нийлүүлэгч** гэсэн монгол үгийг хэрэглэж, **франчаиз, фидуц** гэж буулгах хэрэгтэй.*

5. Судалгааны үр дүн

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсад хэрэглэж буй гэрээний баримт бичгийн хэл зүйн онцлог, үгийн сангийн бүрдэл, хамгийн их давтамжтай үгсийг хөмрөг хэл шинжлэлийн аргаар тодорхойлоход оршиж байсан бөгөөд тавьсан зорилгын хүрээнд илрүүлсэн гол үр дүнг нэгтгэвэл,

Нэгдүгээрт, судалгаанд нийт 84 жишиг гэрээний эхийг ашиглан “Sketch engine” программын тусламжтайгаар хөмрөг бүрдүүлсэн бөгөөд тус хөмрөг нь давтагдсан тоогоор **270,745**, давтагдаагүй тоогоор **15,198** үгтэй байна. Судалгаанаас үзэхэд, гэрээний хэл нь стандартчилсан бүтэцтэй, захирамжлах өнгө аяс давамгайлсан шинжтэй байгааг тогтоов. Үйл үгийн аймгийн хувьд “*шийдвэрлэнэ*”, “*тооцно*”, “*хариуцна*”, “*зохицуулна*”, “*олгоно*” зэрэг –на⁴ төгсгөлтэй үйл үгс өндөр давтамжтай хэрэглэгдэж байгаа нь гэрээний гол үүрэг болох эрх, үүрэг, хариуцлагыг заавал биелүүлэх шинжтэйгээр тогтоох зорилготой нийцэж байна.

Хоёрдугаарт, үгийн сангийн бүрдлийг авч үзэхэд, жинхэнэ нэр болон үйл үг давамгайлж, тэдгээр нь эрх зүйн харилцааны субъект, объект, үйлдэл, үр дагаврыг тодорхойлох үүрэг гүйцэтгэж байв. Ялангуяа “*тал*”, “*гэрээ*”, “*эрх*”, “*үүрэг*”, “*хариуцлага*”, “*төлбөр*” зэрэг нэр томьёо нь гэрээний утга зүйн цөмийг бүрдүүлж, гэрээний заалтыг ойлгомжтой болгоход гол үүрэг гүйцэтгэж байна.

Гуравдугаарт, гэрээний бичвэрт хэрэглэж буй гадаад үгсийн хэрэглээг шинжилж үзэхэд эдийн засаг, санхүү, бизнес, техник-технологи болон хууль эрх зүй, маргаан шийдвэрлэхтэй холбоотой нэр томьёо давамгайлж байгааг тогтоов. Тухайлбал, “*арбитр*”, “*юрисдикц*”, “*акт*”, “*конвенц*”, “*статус*” зэрэг үгс нь гэрээний хэрэгжилт болон маргааныг шийдвэрлэх механизмыг тодорхойлоход чухал үүрэгтэй хэрэглэж байна.

Дөрөвдүгээрт, судалгааны явцад орчуулж болох зарим гадаад үгийг орчуулахгүйгээр олон хувилбараар галиглан хэрэглэх (жишээ нь: *дистрибьютер/дистрибьютор, франчайз/франчиз, фидуци/фидуц*) хандлага ажиглагдсан нь гэрээний ойлгомж, нэр томьёоны нэгдмэл байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг харуулж байна.

6. Дүгнэлт

Гэрээнд хэрэглэж буй үг хэллэг бүрийг буруу, зөрүүтэй ойлгохоос сэргийлэхийн тулд тодорхой, нэгдмэл, тогтвортой, жигд байх ёстой. Хэт ерөнхий, хоёрдмол утгатай, эсвэл аман ярианы үг хэллэг хэрэглэвэл, гэрээг буруу ойлгох, хэрэгжихгүй байх, маргаан үүсэх нөхцөл бүрддэг. Гэрээ нь хэл зүйн хувьд тогтсон бүтэц, давтамжтай нэр томьёо, албан шинжтэй хэллэгээр баялаг юм. Гэрээний хэл найруулга дахь үг хэллэг нь зөвхөн хэлний асуудал биш, эрх зүйн хүчинтэй, ойлгомжтой, маргаангүй гэрээ байгуулах үндэс юм. Хэрэв гэрээний хэл найруулга боловсонгүй байвал, талуудын хооронд итгэлцэл бий болгож, хэрэгжилтийг баталгаажуулдаг.

Гэрээний хэл найруулга нь хожим үүсэх маргаан, шүүхийн шийдвэрийн үед нарийн шалгагддаг тул хэрэглэж буй үгсийн сонголт маш чухал. Хэрэв гэрээний үг, өгүүлбэр тодорхойгүй, хоёрдмол утгатай бол талуудын аль нэг нь хохирол амсах, эрх нь зөрчигдөх эсвэл хууль зүйн хариуцлага хүлээх эрсдэлтэй. Товчхондоо, гэрээний хэл нь албан ёсны, нарийн заагласан, стандарт бүтэцтэй бөгөөд үг зүйн хатуу хэлбэр, утга зүйн нарийвчлал, үгийн сангийн тогтсон хэрэглээ нь гол онцлог болдог.

Цаашид гэрээний хэлийг нарийвчлан судалснаар хуульч, орчуулагч, судлаач нарт зориулсан нэр томъёоны сан, хэл зүйн загвар боловсруулах, гэрээний найруулгын чанарыг сайжруулах, хэлний стандарт боловсруулах, хиймэл оюунд суурилсан гэрээний загварчлалд ашиглах өгөгдлийн эх үүсвэр бий болгох боломжтой.

Ном зүй

- Амартүвшин, Ч., Амгалантөгс, Ц., Анхбаяр, Б., Батболд, Н., Батсүрэн, Б., Баярхүү, Н., Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Өлзийбаяр, С., Пунсаг, А., Төрбат, Ц., Саранбилэг, Ч., Цэвээндорж, Д., Цэнгэл, М., Эгиймаа, Ц., Эрдэнэбат, У., Эрдэнэ-Очир, Н., Эрэгзэн, Г. (2016). *Хүннүгийн толь бичиг*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Amartuvshin, Ch., Amgalantögs, Ts., Ankhbayar, B., Batbold, N., Batsüren, B., Bayarkhüü, N., Gantulga, J., Yerööl-Erdene, Ch., Ölziibayar, S., Punsag, A., Törbat, Ts., Saranbileg, Ch., Tseveendorj, D., Tsengel, M., Egiimaa, Ts., Erdenebat, U., Erdene-Ochir, N., Eregzen, G. *Hünnügiin toli bichig* [Dictionary of Hünnü] Ulaanbaatar: Soyombo printing Co.Ltd. 2016.]
- Аюуш, Д., Амаржаргалан, Г., Давхарбаяр, Ц. (2007). *Гэрээний эрх зүй*. Улаанбаатар: Адмон ХХК. [Ayush, D., Amarjargalan, G., Davkharbayar. *Gereenii erkh züi* [Contract Law] Ulaanbaatar: Admon CoLtd. 2007.]
- Мөнх-Амгалан, Ю. (1998). *Орчин цагийн монгол хэлний баймжийн ай*. Улаанбаатар: МОНЦАМЭ Агентлагийн хэвлэх үйлдвэр. [Mönkh-Amgалан, Yu. *Orchin tsagiin mongol khelnii baimjiin ai* [Category of Modality in Modern Mongolian] Ulaanbaatar: MONTSAME The Publishing company. 1998.]
- Мөнхбат, М. (2023, 12 29). *Олон улсын эрх зүй*. Улаанбаатар, Монгол. [Mönkhbat, M. *Olon ulsyn erkh züi* [International Law] Ulaanbaatar, Mongolia. 2023.]
- Мөнхцэцэг, Н. (2020). *Нэр томъёоны орчуулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Munkhtsetseg, N. *Ner tomyony orchuulga sudlal* [Translation Oriented Terminology Work], Ulaanbaatar: Soyombo printing LLC. 2020.]
- Наранмандах, П. (2022 оны 9 16). *Хууль ёс зүй*. [Naranmandakh, P. *Khuuli Yos Züi* [Legal case] <https://ikon.mn/opinion/>. Retrieved 2022 оны 9 16, <https://ikon.mn/:https://ikon.mn/opinion/2o6h>
- Сүхбаатар, Ц. (2002). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр [Sükhbaatar, Ts. *Mongol khelnii nairuulga züi* [Mongolian stylistics], Ulaanbaatar: NUM Publishing. 2002.]

Tiersma, P. M. (1999). *Legal Language*. University of Chicago Press.

Хантөгс. (2011, 2 11). 1923 онд манай Засгийн газраас Хөлөнбуйрын эрх баригчидтай байгуулсан нэгэн түр гэрээ. Retrieved 2 11, 2011, from <https://olhunud.blogspot.com/>: <https://olhunud.blogspot.com/2011/02/1923.html>

Хууль зүйн зөвөлгөө. (2024 оны 2 25). Хууль зүйн зөвөлгөө. Retrieved 2024, <https://www.legalconsult/100095134284562/posts/>

Xiangwen Sun,Zhiwen Nie. (2013). Application Study on Business Contract Translation Based on Functional Equivalence Theory[C]//. Proceedings of 2013 2nd International Conference on Education Reform and Management Innovation(ERMI 2013) Volume 44.:142-146.